



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 12 сарын 07 өдөр

Дугаар А/482

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн 234 дүгээр
цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 2,220,992.60 (хоёр сая хоёр зуун хорин мянга есөн зуун ерэн хоёр төгрөг жаран мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сүхбаатар дүүргийн 234 дүгээр цэцэрлэг (Ц.Дариймаа)-т зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 2 нэр төрлийн 2,220,992.60 (хоёр сая хоёр зуун хорин мянга есөн зуун ерэн хоёр төгрөг жаран мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 15,000 (арван таван мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 4,500 (дөрвөн мянга таван зуу) төгрөгийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Сүхбаатар дүүргийн 234 дүгээр цэцэрлэг (Ц.Дариймаа)-т, орлого төвлөрүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс (М.Мандах)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050001295



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/182 тоот тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сүхбаатар дүүргийн 234 дүгээр цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	ЭБХХХК-ийн хурлын шийдвэр
Машин, тоног төхөөрөмж											
1	Зөөврийн компьютер /Ноутбук Dell/	6	ш	1	1,835,000	1,835,000.00	1,835,000.00	-	Ашиглах боломжгүй	актлах	5,000
2	Хөлдөөгч /178л/	6	ш	1	385,992.50	385,992.50	385,992.50	-	Ашиглах боломжгүй	актлах	10,000
Машин, тоног төхөөрөмжийн дүн											
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн						2,220,992.50	2,220,992.50	-			15,000
Нүнээс: Худалдах хөрөнгө						2,220,992.50	2,220,992.50	-			15,000
Татан төвлөрүүлэх хөрөнгө						-	-	-			
Устгах хөрөнгө						-	-	-			
Худалдсанаас олох орлого						15,000					
НӨАУГ-т төвлөрүүлэх /30%/						4,500					